



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/101

Алтай хот

Зохицуулалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийн" 25 дахь долоо хоногийн даваа, баасан гарагийн ерөнхий боловсролын сургуулийн танхимын хичээл, сургалтыг 3 дугаар сард нөхөн хичээллэх, сургуулийн өмнөх боловсролыг тус өдрүүдэд амраахаар зохицуулсугай.

2.Хичээл, сургалтын үйл ажиллагааны зохицуулалтыг сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд бүрэн хэрэгжсэн байхаар зохион байгуулж удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР